

**ӨРГӨХ, ЗӨӨХ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЭРХ ОЛГОХ, СУНГАХ
СУРГАЛТЫН АЖЛЫН ДААЛГАВАР**

№	АГУУЛГА	
1	Зорилго	Компанийн салбарын Техник ашиглалт, засвар механикийн хэлтэс болон Захиргаа, удирдлагын хэлтсийн ажилтнуудыг сургалтад хамруулж ур чадварыг мэргэшүүлэх, хөгжүүлэх.
2	Зорилт	1. Сургалтын хэрэгцээнд үндэслэж хамрагдах хүрээг хангаж чадахуйц чанартай, үр дүнтэй сургалтыг зохион байгуулах.
3	Хэрэгцээ, шаардлага	1. Уурхайн өдөр тутмын үйл ажиллагаанд шаардагдах өргөх, зөөх ачаа сэлбэгийг зөв оосорлож, зөв чиглүүлж, аюул осол гаргалгүй ажлыг хийж гүйцэтгэх.
4	Сэдэв	Сургалтыг дараах сэдвүүд болон шаардлагатай бусад сэдвүүдийг нэмж явуулах. • Өргөх, зөөх, тээвэрлэх механизмын бүтэц зохион байгуулалт, онцлогууд; • Өргөх, зөөх, тээвэрлэх механизмын ослоос хамгаалах хэрэгслүүд тэдгээрт тавих хяналт; • Оосорлох хэрэгслүүд, тэдгээрт тавигдах шаардлага, хяналт; • Өргөх, зөөх, тээвэрлэх механизмыг азшиглах үеийн аюулгүй хүчин зүйлүүд, эрсдэлийн үнэлгээ;
5	Хэлбэр	Онол болон практик хосолсон байдлаар
6	Тавигдах шаардлага	<u>Сургалтын байгууллагад:</u> • Тухайн чиглэлээр 5 ба түүнээс дээш жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байсан туршлагатай; • Сүүлийн 5 ба түүнээс дээш жил, тухайн чиглэлээр сургалт явуулж байсан туршлагатай; • Сургалтын хөтөлбөртэй, түүний дагуу сургалтыг явуулах; • Сургалтын өөрийн анги, танхим, хэмжигч багаж, хэрэгслүүдтэй байх; • Сургалтыг хэрэглэгдэхүүн, гарын авлагаар хангах; • Тухай сургалтын агуулга, хугацаа, хамрах хүрээ зэргээс шалтгаалан мэргэжлийн багш нартай байх; • Сургалтад хамрагдсан ажилтнуудад сертификат болон мэргэжлийн үнэмлэх олгох; <u>Сургагч багшид:</u> • Сургагч багш нь тухайн чиглэлийн мэргэжлийн бөгөөд мэргэшсэн байх; • Сургагч багш нь тухайн чиглэлээр 5 ба түүнээс дээш жил ажилласан ажлын туршлагатай байх; • Илтгэх ур чадвар, багшлах ёс зүй хэм хэмжээг мөрддөг байх; • Холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлт, эрх зүйн зохицуулалтын хүрээнд явуулах.
7	Хамрах хүрээ	ТАЗМХ болон ЗУХ
8	Хугацаа	2020 оны 6 дугаар сард Онол практик нийлсэн 10 цаг “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн ээлжийн хуваариас шалтгаалан сургалтыг давамжтай явуулах
9	Төсөв	Сургалтын танхим, сургагч багшийн цалин, сургалтын хэрэглэгдэхүүн сертификат болон бусад зардал
10	Байршил	Улаанбаатар хот “Эрдэнэс-Тавантолгой” ХК
11	Үр дүн	Ажилтнууд тухайн мэргэжлээрээ мэргэшиж, ажлын үр дүн, бүтээмж нэмэгдэнэ.